



2020 оны 07 дугаар сарын 27
№28 /1130/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Их Хурлын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Байнгын хорооны дарга
нарыг сонгох тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалаас
огцруулах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | | |
|------|--|--|------|
| 327. | Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 1534 |
| 328. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1534 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 329. | Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай | Дугаар 9 | 1542 |
| 330. | Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Дугаар 10 | 1544 |
| 331. | Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай | Дугаар 11 | 1550 |
| 332. | Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 12 | 1551 |
| 333. | Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 13 | 1552 |
| 334. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай | Дугаар 14 | 1553 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 335. | Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай | Дугаар 39 | 1553 |
| 336. | Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 49 | 1554 |
| 337. | Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 50 | 1555 |
| 338. | Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай | Дугаар 51 | 1555 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--------------------|-----------|------|
| 339. | Дүрэм батлах тухай | Дугаар 12 | 1556 |
|------|--------------------|-----------|------|

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | | |
|------|--|--|------|
| 340. | Санхүүжилтийн хэлэлцээр (Тогтвортой Амьжиргаа-3 төслийн Нэмэлт санхүүжилт) | | 1563 |
|------|--|--|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан Тогтвортой амьжиргаа-3 төслийн нэмэлт Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 42.1.4 дэх заалт нэмсүгэй:

“42.1.4.төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаал.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг:

“23.3.Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна:

- 23.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын;
- 23.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
- 23.3.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын;
- 23.3.4.Ёс зүй, сахилга хариуцлагын;
- 23.3.5.Инновац, цахим бодлогын;
- 23.3.6.Нийгмийн бодлогын;
- 23.3.7.Төрийн байгуулалтын;
- 23.3.8.Төсвийн;

- 23.3.9.Үйлдвэржилтийн бодлогын;
- 23.3.10.Хууль зүйн;
- 23.3.11.Эдийн засгийн.”

2/24 дүгээр зүйл:

“24 дүгээр зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ

24.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

- 24.1.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;
- 24.1.2.Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;
- 24.1.3.төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;
- 24.1.4.гадаад бодлого;
- 24.1.5.гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудал;

24.1.6.Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал;

24.1.7.цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого.

24.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

24.2.1.газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;

24.2.2.хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;

24.2.3.хөдөөгийн хөгжлийн бодлого;

24.2.4.мал аж ахуйн бодлого;

24.2.5.малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах;

24.2.6.газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;

24.2.7.улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;

24.2.8.геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;



24.2.9.агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;
24.2.10.цаг уур, орчны хяналтын асуудал;
24.2.11.усны бодлого, нөөц, усны бохирдол;
24.2.12.хөг хаягдал, дахин боловсруулалт;
24.2.13.байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал;

24.2.14.байгаль орчны судалгаа, хөгжил;
24.2.15.ан агнуур;
24.2.16.газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт;
24.2.17.газрын кадастр, зураглал.

24.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо:

24.3.1.боловсрол;
24.3.2.соёл, урлаг;
24.3.3.ард түмний түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого;

24.3.4.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил;

24.3.5.шинжлэх ухаан;
24.3.6.нийтийн биеийн тамир, спорт.

24.4.Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо:

24.4.1.төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын бодлого;

24.4.2.төрийн албаны бүх шатны ёс зүйн хорооны асуудал;
24.4.3.гишүүний ёс зүй, сахилгын асуудал;
24.4.4.чуулганы хуралдааны дэг сахиулах;
24.4.5.гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;
24.4.6.Улсын Их Хурлын болон гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт;

24.4.7.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын асуудал;

24.4.8.нэгдсэн хуралдааны ирцийн асуудал;
24.4.9.гишүүний ёс зүйн асуудлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

24.4.10.Улсын Их Хурлыг үл хүндэтгэсэн үйлдэлд хяналт тавих.



24.5.Инновац, цахим бодлогын байнгын хороо:

- 24.5.1.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа;
- 24.5.2.мэдээллийн технологийн хөгжил;
- 24.5.3.харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;
- 24.5.4.өндөр технологи, үндэсний инновацын бодлого;
- 24.5.5.дигитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;
- 24.5.6.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого;

24.5.7.инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд нэвтрүүлэх хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого;

24.5.8.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого;

24.5.9.инновацын үйл ажиллагааг санхүүжүүлэх бодлого.

24.6.Нийгмийн бодлогын байнгын хороо:

- 24.6.1.хүн амын хөгжлийн бодлого;
- 24.6.2.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого;

бодлого;

24.6.3.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа;

- 24.6.4.мэргэжлийн боловсрол, сургалт;
- 24.6.5.жендэрийн тэгш байдлыг хангах бодлого;
- 24.6.6.эрүүл мэндийн бодлого.

24.7.Төрийн байгуулалтын байнгын хороо:

- 24.7.1.Үндсэн хуулийн шинэтгэлийн асуудал;
- 24.7.2.төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;

бодлого;

24.7.3.засаг захиргааны шинэтгэл, төвлөрлийг сааруулах бодлого;

24.7.4.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, хот, тосгоны Зөвлөл, Захирагчийн сонгууль;



24.7.5.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, хот, тосгоны эрх зүйн үндэс;

24.7.6.төрийн алба;

24.7.7.төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;

24.7.8.ард нийтийн санал асуулга;

24.7.9.төр, сүм хийдийн харилцаа;

24.7.10.хэвлэл мэдээллийн хараат бус байдал;

24.7.11.төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай

харилцах;

24.7.12.гишүүний бүрэн эрхийн асуудал;

24.7.13.гишүүний бүрэн эрхийн баталгаа;

24.7.14.чуулганы хуралдааны дэгийн асуудал;

24.7.15.бүсчилсэн хөгжлийн бодлого.

24.8.Төсвийн байнгын хороо:

24.8.1.улсын нэгдсэн төсөв, түүний гүйцэтгэл, хяналт;

24.8.2.төрийн санхүү, зээлийн болон татварын бодлого;

24.8.3.аудитын асуудал;

24.8.4.гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл;

24.8.5.Засгийн газрын тусгай сангийн нэгдсэн бодлого;

24.8.6.Улсын Их Хурлын төсөв;

24.8.7.төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал.

24.9.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо:

24.9.1.үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт;

24.9.2.жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

24.9.3.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

24.9.4.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого.

24.10.Хууль зүйн байнгын хороо:

24.10.1.эрх зүйн бодлого;

24.10.2.хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа;

24.10.3.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого;

24.10.4.улсын хил хамгаалалтын бодлого;
24.10.5.хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс,
ялын бодлого;

24.10.6.шүүх эрх мэдэл;
24.10.7.прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн
шийдвэр гүйцэтгэл;

24.10.8.нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;
24.10.9.эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргаан, зөрчил хянан
шийдвэрлэх ажиллагаа;

24.10.10.өршөөл үзүүлэх асуудал;
24.10.11.патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг;
24.10.12.цагаачлал, иргэний харьяалал;
24.10.13.архив;
24.10.14.эрх зүйн туслалцаа;
24.10.15.өмгөөлөл;
24.10.16.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын
бүртгэл.

24.11.Эдийн засгийн байнгын хороо:

24.11.1.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл;
24.11.2.эдийн засгийн дотоод, гадаад бодлого;
24.11.3.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
24.11.4.төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл
ажиллагаа;

24.11.5.даатгалын бодлого, энэ хуулийн 24.8.7-д зааснаас
бусад үнэт цаасны тухай асуудал;

24.11.6.төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын
бодлого;

24.11.7.гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн
нэгдсэн бодлого;

24.11.8.ашигт малтмалын суурь судалгаа, эрэл хайгуул,
ашиглалтын бодлого;

24.11.9.газрын тос, байгалийн хийн асуудал;
24.11.10.үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого;
24.11.11.шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого;



24.11.12.төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;
24.11.13.стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт;

24.11.14.албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт;

24.11.15.барилга, хот байгуулалт;

24.11.16.түлш, эрчим хүч;

24.11.17.зам тээвэр, шуудан;

24.11.18.орон сууц, нийтийн аж ахуй;

24.11.19.аялал жуулчлалын хөгжлийн стратеги;

24.11.20.аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил;

24.11.21.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого.”

3/28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэг:

“28.1.Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулж болно:

28.1.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын;

28.1.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаарын бохирдлыг бууруулах асуудлын;

28.1.3.Төрийн байгуулалтын байнгын хороонд Нутгийн удирдлагын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын;

28.1.4.Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын;

28.1.5.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн, Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн, Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн;

28.1.6.Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн;

28.1.7.Эдийн засгийн байнгын хороонд Тогтвортой хөгжлийн зорилгын.

28.2.Дэд хороо харьяалагдах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцан санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд дараах асуудлыг эрхэлнэ:

28.2.1. Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;

28.2.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хороо нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын асуудлыг;

28.2.3. Нутгийн удирдлагын дэд хороо нь нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн удирдлагын байгууллагын төлөвшил, хөгжил, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг;

28.2.4. Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо нь сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;

28.2.5. Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг;

28.2.6. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо нь улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;

28.2.7. Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх асуудлыг;

28.2.8. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хурал, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;

28.2.9. Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо нь хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудлыг;

28.2.10. Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо нь хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудлыг;

28.2.11. Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “15-19” гэснийг “19 хүртэл” гэж, мөн хэсгийн “хоёроос” гэснийг “гурваас” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “Улсын



Их Хурлын дарга захирамжаар” гэснийг “Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолоор” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “Ёс зүйн болон” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/Тусгай хяналтын:

- 1.Норовын Алтанхуяг
- 2.Төмөрбаатарын Аюурсайхан
- 3.Сүхбаатарын Батболд
- 4.Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- 5.Борхүүгийн Дэлгэрсайхан
- 6.Цэдэвийн Сэргэлэн
- 7.Бямбасүрэнгийн Энх-Амгалан

2/Агаарын бохирдлыг бууруулах асуудлын:

- 1.Балжиннямын Баярсайхан
- 2.Гочоогийн Ганболд
- 3.Гонгорын Дамдинням
- 4.Батсүхийн Саранчимэг
- 5.Цэвэгдоржийн Туваан
- 6.Жигжидсүрэнгийн Чинбүрэн

3/Ёс зүйн:

- 1.Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ



2. Буланы Бейсен
3. Лхагвын Мөнхбаатар
4. Жамъянхорлоогийн Сүхбаатар
5. Ганзоригийн Тэмүүлэн

4/Нутгийн удирдлагын:

1. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
2. Жамбын Батсуурь
3. Гочоогийн Ганболд
4. Хишгээгийн Нямбаатар
5. Жамъянхорлоогийн Сүхбаатар

5/Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын:

1. Жамбалын Ганбаатар
2. Жамъянгийн Мөнхбат
3. Цэндийн Мөнх-Оргил
4. Бөхчулууны Пүрэвдорж
5. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан

6/Төсвийн зарлагын хяналтын:

1. Ганибалын Амартүвшин
2. Цогт-Очирын Анандбазар
3. Жигжидийн Батжаргал
4. Жамбын Батсуурь
5. Баагаагийн Баттөмөр
6. Хүрэлбаатарын Булгантуяа
7. Сайнхүүгийн Ганбаатар
8. Бөхчулууны Пүрэвдорж
9. Ганзоригийн Тэмүүлэн

7/Хүний эрхийн:

1. Ширнэнбаньдын Адьшаа
2. Дашдондогийн Ганбат
3. Цэрэнжамцын Мөнхцэцэг
4. Шатарбалын Раднаасэд
5. Цэндийн Сандаг-Очир
6. Ням-Осорын Учрал
7. Баттөмөрийн Энхбаяр

8/Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн:

1. Энхтайваны Бат-Амгалан
2. Дамбын Батлут
3. Жадамбын Бат-Эрдэнэ
4. Жамбалын Ганбаатар
5. Хассуурийн Ганхуяг
6. Тогмидын Доржханд



7. Мөнхөөгийн Оюунчимэг
8. Одонгийн Цогтгэрэл
9. Баттөмөрийн Энхбаяр

9/Тогтвортой хөгжлийн зорилгын:

1. Сайнбуянгийн Амарсайхан
2. Баагаагийн Баттөмөр
3. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
4. Наянтайн Ганибал
5. Болдын Жавхлан

2. Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

1. Ширнэнбаньдын Адьшаа
2. Норовын Алтанхуяг
3. Пүрэв-Очирын Анужин
4. Төмөрбаатарын Аюурсайхан
5. Хавдисламын Баделхан
6. Энхтайваны Бат-Амгалан
7. Сүхбаатарын Батболд
8. Баагаагийн Баттөмөр
9. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
10. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ



11. Дашдондогийн Ганбат
12. Тогмидын Доржханд
13. Борхүүгийн Дэлгэрсайхан
14. Нанзадын Наранбаатар
15. Цэдэвийн Сэргэлэн
16. Дамдины Цогтбаатар
17. Бямбасүрэнгийн Энх-Амгалан
18. Нямаагийн Энхболд

2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

1. Цогт-Очирын Анандбазар
2. Телуханы Аубакар
3. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
4. Жигжидийн Батжаргал
5. Жадамбын Бат-Эрдэнэ
6. Буланы Бейсен
7. Хаянгаагийн Болорчулуун
8. Гочоогийн Ганболд
9. Наянтайн Ганибал
10. Гонгорын Дамдинням
11. Гомпилдоогийн Мөнхцэцэг
12. Нанзадын Наранбаатар
13. Дамдинсүрэнгийн Өнөрболор
14. Батсүхийн Саранчимэг
15. Цэвэгдоржийн Туваан
16. Ганзоригийн Тэмүүлэн
17. Одонгийн Цогтгэрэл
18. Цэдэндамбын Цэрэнпунцаг
19. Төмөртоогоогийн Энхтүвшин

3/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо:

1. Амгалангийн Адъяасүрэн
2. Ганибалын Амартүвшин
3. Пүрэв-Очирын Анужин
4. Телуханы Аубакар
5. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
6. Балжиннямын Баярсайхан
7. Хассуурийн Ганхуяг
8. Гонгорын Дамдинням
9. Бадарчийн Жаргалмаа
10. Жамъянгийн Мөнхбат



- 11.Гомпилдоогийн Мөнхцэцэг
- 12.Цэрэнжамцын Мөнхцэцэг
- 13.Дамдинсүрэнгийн Өнөрболор
- 14.Даваажанцангийн Сарангэрэл
- 15.Жигжидсүрэнгийн Чинбүрэн
- 16.Чинбатын Ундрал
- 17.Ням-Осорын Учрал
- 18.Төмөртоогогийн Энхтүвшин

4/Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо:

- 1.Ширнэнбаньдын Адьшаа
- 2.Хавдисламын Баделхан
- 3.Баагаагийн Баттөмөр
- 4.Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 5.Балжиннямын Баярсайхан
- 6.Буланы Бейсен
- 7.Сандагийн Бямбацогт
- 8.Жамъянгийн Мөнхбат
- 9.Мөнхөөгийн Оюунчимэг
- 10.Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- 11.Баттөмөрийн Энхбаяр

5/Инновац, цахим бодлогын байнгын хороо:

- 1.Ганибал Амартүвшин
- 2.Энхтайваны Бат-Амгалан
- 3.Дамбын Батлут
- 4.Сайнхүүгийн Ганбаатар
- 5.Наянтайн Ганибал
- 6.Хассуурийн Ганхуяг
- 7.Гонгорын Дамдинням
- 8.Тогмидын Доржханд
- 9.Цэрэнжамцын Мөнхцэцэг
- 10.Батсүхийн Саранчимэг
- 11.Цэдэвийн Сэргэлэн
- 12.Ням-Осорын Учрал
- 13.Жигжидсүрэнгийн Чинбүрэн

6/Нийгмийн бодлогын байнгын хороо:

- 1.Пүрэв-Очирын Анужин
- 2.Дамбын Батлут
- 3.Балжиннямын Баярсайхан

4. Буланы Бейсен
5. Сайнхүүгийн Ганбаатар
6. Бадарчийн Жаргалмаа
7. Цэндийн Мөнх-Оргил
8. Салдангийн Одонтуяа
9. Мөнхөөгийн Оюунчимэг
10. Цэндийн Сандаг-Очир
11. Даваажанцангийн Сарангэрэл
12. Батсүхийн Саранчимэг
13. Цэвэгдоржийн Туваан
14. Чинбатын Ундрэм
15. Жигжидсүрэнгийн Чинбүрэн
16. Содномын Чинзориг
17. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан

7/Төрийн байгуулалтын байнгын хороо:

1. Амгалангийн Адъяасүрэн
2. Сайнбуянгийн Амарсайхан
3. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
4. Жамбын Батсуурь
5. Сандагийн Бямбацогт
6. Жамбалын Ганбаатар
7. Гочоогийн Ганболд
8. Гомбожавын Занданшатар
9. Жамъянгийн Мөнхбат
10. Цэндийн Мөнх-Оргил
11. Хишгээгийн Нямбаатар
12. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
13. Бөхчулууны Пүрэвдорж
14. Долгорсүрэнгийн Сумъяабазар
15. Жамъянхорлоогийн Сүхбаатар
16. Дуламдоржийн Тогтохсүрэн
17. Ухнаагийн Хүрэлсүх
18. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
19. Нямаагийн Энхболд

8/Төсвийн байнгын хороо:

1. Сайнбуянгийн Амарсайхан
2. Ганибалын Амартүвшин
3. Цогт-Очирын Анандбазар
4. Хавдисламын Баделхан
5. Жигжидийн Батжаргал



6. Жамбын Батсуурь
7. Хүрэлбаатарын Булгантуяа
8. Сайнхүүгийн Ганбаатар
9. Цэрэнпилийн Даваасүрэн
10. Болдын Жавхлан
11. Лхагвын Мөнхбаатар
12. Салдангийн Одонтуяа
13. Бөхчулууны Пүрэвдорж
14. Шатарбалын Раднаасэд
15. Долгорсүрэнгийн Сумъяабазар
16. Дуламдоржийн Тогтохсүрэн
17. Ганзоригийн Тэмүүлэн
18. Чимэдийн Хүрэлбаатар
19. Баттогтохын Чойжилсүрэн

9/Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо:

1. Амгалангийн Адъяасүрэн
2. Цогт-Очирын Анандбазар
3. Телуханы Аубакар
4. Жигжидийн Батжаргал
5. Жадамбын Бат-Эрдэнэ
6. Гочоогийн Ганболд
7. Нанзадын Наранбаатар
8. Дамдинсүрэнгийн Өнөрболор
9. Шатарбалын Раднаасэд
10. Цэвэгдоржийн Туваан
11. Ганзоригийн Тэмүүлэн
12. Одонгийн Цогтгэрэл
13. Баттогтохын Чойжилсүрэн
14. Төмөртогоогийн Энхтүвшин

10/Хууль зүйн байнгын хороо:

1. Ширнэнбаньдын Адьшаа
2. Норовын Алтанхуяг
3. Сайнбуянгийн Амарсайхан
4. Сандагийн Бямбацогт
5. Дашдондогийн Ганбат
6. Борхүүгийн Дэлгэрсайхан
7. Лхагвын Мөнхбаатар
8. Цэрэнжамцын Мөнхцэцэг
9. Хишгээгийн Нямбаатар

- 10.Бөхчулууны Пүрэвдорж
- 11.Шатарбалын Раднаасэд
- 12.Цэндийн Сандаг-Очир
- 13.Жамъянхорлоогийн Сүхбаатар
- 14.Цэдэвийн Сэргэлэн
- 15.Ням-Осорын Учрал
- 16.Дамдины Цогтбаатар
- 17.Бямбасүрэнгийн Энх-Амгалан
- 18.Баттөмөрийн Энхбаяр

11/Эдийн засгийн байнгын хороо:

- 1.Төмөрбаатарын Аюурсайхан
- 2.Энхтайваны Бат-Амгалан
- 3.Дамбын Батлут
- 4.Баагаагийн Баттөмөр
- 5.Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- 6.Жадамбын Бат-Эрдэнэ
- 7.Хаянгаагийн Болорчулуун
- 8.Хүрэлбаатарын Булгантуяа
- 9.Жамбалын Ганбаатар
- 10.Наянтайн Ганибал
- 11.Хассуурийн Ганхуяг
- 12.Цэрэнпилийн Даваасүрэн
- 13.Тогмидын Доржханд
- 14.Болдын Жавхлан
- 15.Мөнхөөгийн Оюунчимэг
- 16.Одонгийн Цогтгэрэл
- 17.Цэдэндамбын Цэрэнпунцаг
- 18.Содномын Чинзориг
- 19.Баттөмөрийн Энхбаяр

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын Байнгын хороодын даргаар дараах Улсын Их Хурлын гишүүдийг сонгосугай:

1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Баагаагийн Баттөмөрийг;

2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Хаянгаагийн Болорчулууныг;

3/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Жамъянгийн Мөнхбатыг;

4/Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг;

5/Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Ням-Осорын Учралыг;

6/Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Мөнхөөгийн Оюунчимэгийг;

7/Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг;

8/Төсвийн байнгын хорооны даргаар Болдын Жавхланг;

9/Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Баттогтохын Чойжилсүрэнг;

10/Хууль зүйн байнгын хорооны даргаар Сандагийн Бямбацогтыг;

11/Эдийн засгийн байнгын хорооны даргаар Жамбалын Ганбаатарыг.

2.Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 9 дүгээр тогтоолд доор дурдсан агуулгатай 7, 8 дахь дэд заалт нэмсүгэй:

“7/Хөнгөн үйлдвэрлэлийн:

- 1.Амгалангийн Адъяасүрэн
- 2.Цогт-Очирын Анандбазар
- 3.Телуханы Аубакар
- 4.Дамдинсүрэнгийн Өнөрболор
- 5.Шатарбалын Раднаасэд
- 6.Ганзоригийн Тэмүүлэн
- 7.Цэвэгдоржийн Туваан

8/Хүнд үйлдвэрлэлийн:

- 1.Цогт-Очирын Анандбазар
- 2.Нанзадын Наранбаатар
- 3.Одонгийн Цогтгэрэл
- 4.Баттогтохын Чойжилсүрэн
- 5.Ганзоригийн Тэмүүлэн
- 6.Төмөртоогоогийн Энхтүвшин
- 7.Цэвэгдоржийн Туваан

2.Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарыг Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Дамбын Батлут, Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд, Мөнхөөгийн Оюунчимэг, Одонгийн Цогтгэрэл, Баттөмөрийн Энхбаяр нарыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны, Улсын Их Хурлын



гишүүн Сайнбуянгийн Амарсайханыг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Улсын Их Хурлын гишүүн Телуханы Аубакарыг Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайханыг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адъяасүрэн, Жигжидийн Батжаргал, Гочоогийн Ганболд, Төмөртоогоогийн Энхтүвшин нарыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд нарыг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны гишүүнээр тус тус баталсугай.

4.“Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4, 5, 6 дахь дэд заалтын дугаарыг “3, 4, 5” гэж, мөн заалтын 8 дахь дэд заалтын дугаарыг “6” гэж, 7, 9 дэх дэд заалтын дугаарыг “9, 10” гэж, мөн заалтын 8 дахь дэд заалтын гарчгийг “Жижиг, дунд үйлдвэрлэлийн:” гэж тус тус өөрчилсүгэй.

5.“Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 09 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хүчингүй болгосугай.

6.Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 13¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь хүсэлтийг харгалзан Аюушийн Ариунзаяаг Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.10 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэг гэж хүлээн зөвшөөрсөнд тооцсугай.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасны дагуу шийдвэрлэсүгэй.

3.Энэ тогтоолыг 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



1. Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгч Цогтбаярын Урангуаг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрбаатарын Бадрахыг Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Пүрэвийн Пагмыг Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгч Бүрэнсэдийн Эрдэнэмөнхийг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Гэндэнгийн Алгирмааг Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсон тул шүүгч Цогтбаярын Урангуаг Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн, шүүгч Төмөрбаатарын Бадрахыг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Пүрэвийн Пагмыг Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Бүрэнсэдийн Эрдэнэмөнхийг Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн, шүүгч Гэндэнгийн Алгирмааг Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.3, 18.7-д заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Пандийн Долгормааг Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Мөнхдөлийн Түмэннастыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дашцоодолын Нямбазарыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Бямбаагийн Ариунхишигийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Даваанямын Оюумаа, Намжилын Долгорсүрэн нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Шүүгч Дашцоодолын Нямбазарыг Дархан-Уул аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, шүүгч Бямбаагийн Ариунхишигийг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Даваанямын Оюумаа, Намжилын Долгорсүрэн нарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Батжаргалын Батзоригийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Говьсүмбэр аймаг дахь



Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Нанзадын Дамдинсүрэнг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Лхагвадуламын Батбаатарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Цэрэнчимэдийн Мөнхтулгыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Лувсандоржийн Одончимэгийг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Аюурзанын Энхтөрийг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ванчинсүрэнгийн Амартүвшинг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсон тул шүүгч Батжаргалын Батзоригийг Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, шүүгч Нанзадын Дамдинсүрэнг Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Лхагвадуламын Батбаатарыг Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Цэрэнчимэдийн Мөнхтулгыг Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, шүүгч Лувсандоржийн Одончимэгийг Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Аюурзанын Энхтөрийг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Ванчинсүрэнгийн Амартүвшинг Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны дүрмийг 1 дүгээр хавсралт, Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хамгаалалтын захиргааны дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2020 оны 12 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ АЛТАЙН ХАДНЫ ЗУРГИЙН ЦОГЦОЛБОРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа (цаашид “Хамгаалалтын захиргаа” гэх) нь Монгол Алтайн хадны зургийн цогцолборын эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, сурталчлах, хөгжүүлэх чиг үүрэг бүхий соёлын байгууллага мөн.

1.2. Хамгаалалтын захиргаа нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, хэлэлцээр, энэ дүрмийг мөрдөнө.

1.3. Хамгаалалтын захиргаа нь зохих хууль, журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

1.5. Хамгаалалтын захиргаа нь Баян-Өлгий аймагт байрлана.

Хоёр. Хамгаалалтын захиргааны чиг үүрэг

2.1. Хамгаалалтын захиргаа нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



2.1.1. байгалийн болон соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

2.1.2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд заасан хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт дэглэм тогтоож мөрдүүлэх;

2.1.3. дурсгалт газраар аялах маршрут тогтоох, аялагчдыг мэдээллээр хангах;

2.1.4. хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

2.1.5. гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, дурсгалт газрын байгалийн болон соёлын өвийг хамгаалах талаар хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.1.6. байгалийн болон соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдалд хохирол учруулж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.1.7. дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын талаар яам, холбогдох бусад газрыг шуурхай мэдээллээр хангах;

2.1.8. тогтоосон хугацаанд дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дэлгэрэнгүй тайланг бэлтгэж, хүргүүлэх;

2.1.9. дурсгалт газарт үзлэг, шалгалт хийх;

2.1.10. харьяалах орон нутгийн удирдлага, ард иргэдтэй хамтран ажиллах, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих;

2.1.11. дурсгалт газрын байгаль, соёлын өвийг судлах ажлыг бие даан болон мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.1.12. дурсгалт газрын ойролцоох соёлын өвийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих;

2.1.13. эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах;

2.1.14. дурсгалт газрыг олон нийтэд сурталчлан таниулах;

2.1.15. эрх бүхий байгууллагаас өгсөн бусад чиг үүрэг.

2.2. Хамгаалалтын захиргаа энэ дүрмийн 2.1.9-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн иргэдээр гүйцэтгүүлж болно.

Гурав. Хамгаалалтын захиргааны
бүтэц, удирдлага

3.1. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг дарга удирдан зохион байгуулна. Даргыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.1.16-д заасны дагуу соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

3.2. Хамгаалалтын захиргааны даргаар соёлын өвийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн, дадлага туршлагатай, эрдмийн зэрэг цол, гадаад хэлний зохих мэдлэгтэй хүнийг сонгон шалгаруулж ажиллуулна.

3.3. Хамгаалалтын захиргааны ажилтнуудыг орон нутгийн иргэдээс сонгон шалгаруулж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах зарчим баримтална.

3.4. Хамгаалалтын захиргааны дарга байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.

3.5. Хамгаалалтын захиргааны дарга дараах бүрэн эрхтэй:

3.5.1. хамгаалалтын захиргаанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бодлого, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.5.2. хууль тогтоомж, Засгийн газрын болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.3. хамгаалалтын захиргааны ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд томилж, чөлөөлөх;

3.5.4. эрх мэдлийн хүрээнд тушаал гаргаж хэрэгжилтийг хангуулах;

3.5.5. байгууллагын төсвийг хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнах;

3.5.6. эрх мэдлийн хүрээнд байгууллагын эд хөрөнгийг захиран зарцуулах, хэлцэл хийх, гэрээ байгуулах;



3.5.7. ажилтныг шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд тодорхойлох;

3.5.8. хамгаалалтын захиргааг гадаад улс болон дотоодод төлөөлөх;

3.5.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.7. Хамгаалалтын захиргааны дарга дурсгалт газрын хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг сайн дурын үндсэн дээр зохион байгуулалттайгаар оролцуулж болно.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

БУРХАН ХАЛДУН УУЛ, ТҮҮНИЙГ ХҮРЭЭЛСЭН ТАХИЛГАТ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа (цаашид “Хамгаалалтын захиргаа” гэх) нь Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт байрлах байгалийн болон соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, сурталчлах, хөгжүүлэх чиг үүрэг бүхий соёлын байгууллага мөн.

1.2. Хамгаалалтын захиргаа нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, хэлэлцээр, энэ дүрмийг мөрдөнө.

1.3. Хамгаалалтын захиргаа нь зохих хууль, журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

1.5. Хамгаалалтын захиргаа нь Улаанбаатар хотод байрлана.

Хоёр. Хамгаалалтын захиргааны чиг үүрэг

2.1. Хамгаалалтын захиргаа нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. байгалийн болон соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;



2.1.2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд заасан хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт дэглэм тогтоож мөрдүүлэх;

2.1.3. Хан Хэнтийн уулсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай хамтран дурсгалт газар аялах маршрут тогтоох, аялагчдыг мэдээллээр хангах;

2.1.4. хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

2.1.5. гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, дурсгалт газрын байгалийн болон соёлын өвийг хамгаалах талаар хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.1.6. байгалийн болон соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдалд хохирол учруулж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.1.7. дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын талаар яам, холбогдох бусад газрыг шуурхай мэдээллээр хангах;

2.1.8. тогтоосон хугацаанд дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дэлгэрэнгүй тайланг бэлтгэж, хүргүүлэх;

2.1.9. дурсгалт газарт үзлэг, шалгалт хийх;

2.1.10. харьяалах орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих;

2.1.11. дурсгалт газрын байгаль, соёлын өвийг судлах ажлыг бие даан болон мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.1.12. дурсгалт газрын ойролцоох соёлын өвийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих;

2.1.13. эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах;

2.1.14. дурсгалт газрыг олон нийтэд сурталчлан таниулах;

2.1.15. эрх бүхий байгууллагаас өгсөн бусад чиг үүрэг.

2.2. Хамгаалалтын захиргаа энэ дүрмийн 2.1.9-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн иргэдээр гүйцэтгүүлж болно.



Гурав. Хамгаалалтын захиргааны
бүтэц, удирдлага

3.1. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг дарга удирдан зохион байгуулна. Даргыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.1.16-д заасны дагуу соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

3.2. Хамгаалалтын захиргааны даргаар соёлын өвийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн, дадлага туршлагатай, эрдмийн зэрэг цол, гадаад хэлний зохих мэдлэгтэй хүнийг сонгон шалгаруулж ажиллуулна.

3.3. Хамгаалалтын захиргааны ажилтнуудыг орон нутгийн иргэдээс сонгон шалгаруулж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах зарчим баримтална.

3.4. Хамгаалалтын захиргааны дарга байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.

3.5. Хамгаалалтын захиргааны дарга дараах бүрэн эрхтэй;

3.5.1. хамгаалалтын захиргаанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бодлого, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.5.2. хууль тогтоомж, Засгийн газрын болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.3. хамгаалалтын захиргааны ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд томилж, чөлөөлөх;

3.5.4. эрх мэдлийн хүрээнд тушаал гаргаж хэрэгжилтийг хангуулах;

3.5.5. байгууллагын төсвийг хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнах;

3.5.6. эрх мэдлийн хүрээнд байгууллагын эд хөрөнгийг захиран зарцуулах, хэлцэл хийх, гэрээ байгуулах;

3.5.7. ажилтныг шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд тодорхойлох;

3.5.8. хамгаалалтын захиргааг гадаад улс болон дотоодод төлөөлөх;

3.5.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.6. Хамгаалалтын захиргааны дарга дурсгалт газрын хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг сайн дурын үндсэн дээр зохион байгуулалттайгаар оролцуулж болно.

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

(Тогтвортой Амьжиргаа-3 төслийн Нэмэлт санхүүжилт)

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын хэлэлцээр

ЗЭЭЛИЙН ДУГААР 6588 -МН

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү ХЭЛЭЛЦЭЭР нь МОНГОЛ УЛС (“Хүлээн авагч”) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (“Ассоциаци”) нар гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна.

(А) Хүлээн авагч болон Ассоциаци хооронд 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурж, 2017 оны 9 дүгээр сарын 24-нд өөрчлөлт оруулсан хэлэлцээр (“Анхны санхүүжилтийн хэлэлцээр”)-ийн дагуу Ассоциаци нь Анхны санхүүжилтийн хэлэлцээр (“Эх төсөл”)-ийн 1-р Хуваарьт тусгасан төсөлд санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилгоор арван зургаан сая нэг зуун мянган Зээлийн тусгай эрх (ЗТЭ 16,100,000) (“Анхны зээл”)-тэй дүйцэх хөнгөлөлттэй зээлийг Хүлээн авагчид олгохыг хүлээн зөвшөөрсөн; БОЛОХЫГ ХАРГАЛЗАН ҮЗЭЖ, мөн

(Б) Анхны санхүүжилтийн хэлэлцээртэй холбоотой нэмэлт үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хүлээн авагч нь Ассоциациас санхүүжилтийн дэмжлэг хүссэн бөгөөд Ассоциаци хүсэлтийг хүлээн зөвшөөрч, энэхүү Хэлэлцээр болон бусад холбогдох хэлэлцээрт заасан нөхцөлүүдийн дагуу санхүүжилтийн дэмжлэг үзүүлэхээр болсон;

ЭДГЭЭРТ ҮНДЭСЛЭН, Хүлээн авагч болон Ассоциаци дараах зүйлсийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

I БҮЛЭГ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД; НЭР ТОМЬЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан) энэхүү Хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх төдийгүй энэхүү Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн болно.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёонууд нь Ерөнхий нөхцөлүүд, Анхны санхүүжилтийн хэлэлцээр, эсвэл энэхүү хэлэлцээрт (Оршил ба хавсралт хэсгийг оролцуулаад) тайлбарласан утгыг илэрхийлнэ.



II БҮЛЭГ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т тусгасан төслийг (“Төсөл”) санхүүжүүлэх зорилгоор Ерөнхий нөхцөлүүдийн дагуу найман сая найман зуун мянган ЗТЭ (ЗТЭ 8,800,000) (өөрөөр “Зээл”, “Санхүүжилт” гэх)-тэй тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг Хүлээн авагчид олгохыг хүлээн зөвшөөрч байна.
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн III хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах боломжтой.
- 2.03. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгийг баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 3 дугаар сарын 1 болон 9 дүгээр сарын 1- ний өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт ам.доллар байна.

III БҮЛЭГ — ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч нь төслийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлийн V Бүлэг болон Хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан заалтуудад нийцүүлж, Сангийн ямаар дамжуулан төслийг хэрэгжүүлнэ.

IV БҮЛЭГ — АССОЦИАЦИАС АВЧ БОЛОХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- 4.01. Хүлээн авагч нь Орон нутгийн хөгжлийн санг татан буулгаж, эрхийг нь хааж, үйл ажиллагааг нь зогсоосон, эсвэл эдгээрийг хийхэд хүргэсэн тохиолдолд хэлэлцээрийг түдгэлзүүлэх нэмэлт нөхцөл бүрдсэн гэж үзнэ.
- 4.02. Энэхүү Хэлэлцээрийн 4.01-ийн (а) хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Идэвхжүүлэх нэмэлт арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

V БҮЛЭГ —ЦУЦЛАХ

- 5.01. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Гарын үсэг зурсан өдрөөс нэг зуун наян (180) хоног байна.

- 5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 10.05 (б) Хэсэгт тусгасны дагуу Хүлээн авагчийн Хэлэлцээрийн үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) гарын үсэг зурсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

VI БҮЛЭГ — ТӨЛӨӨЛӨГЧИД; ХОЛБОГДОХ ХАЯГУУД

- 6.01. Хүлээн авагчийг төлөөлөх байгууллага нь тухайн үеийн санхүү хариуцсан яам байх болно.
- 6.02. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Хүлээн авагчийн хаяг нь:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С. Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар 15160
Монгол Улс

ба

(б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс:
976-11-320247

- 6.03. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Ассоциацийн хаяг нь:

Олон улсын хөгжлийн ассоциаци
1818 H Street, N.W.
Вашингтон хот. 20433
АНУ; мөн

(б) Ассоциацийн цахим хаяг нь:

Телекс: Факс:
248423 (MCI) 1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр **ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.**

МОНГОЛ УЛСЫН ТАЛААС

Гарын үсэг зурсан

Эрх мэдэл бүхий төлөөлөгч

Нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____



ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ-ийн талаас

Гарын үсэг зурсан

Эрх мэдэл бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь Монгол улсын хөдөө орон нутагт нэн тэргүүнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал, олон нийтийн оролцоог бэхжүүлэхэд чиглэсэн болно.

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1-р Хэсэг: Орон нутгийн засаглал, амьжиргааны чадавхыг бэхжүүлэх

- (а) Орон нутгийн засаг захиргаа, иргэд, олон нийтэд Орон нутгийн хөгжлийн санг хэрэгжүүлэх, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт, иргэдийн оролцоо, төсөв боловсруулах ба батлах, төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа ба удирдлага, тайлагналт, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, бэлчээрийн төлөвлөлт, удирдлага зэрэг сэдвээр сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлнэ.
- (б) Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой эдийн засаг, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх төрийн захиргааны төв байгууллагад техникийн туслалцаа үзүүлэх.

2-р Хэсэг: Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан дэмжлэгийн хөтөлбөр

- (а) Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлж, урамшуулал авах болзол хангасан Сумдад сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох.
- (б) Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг тодорхойлох зорилгоор Сумдад жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх.
- (в) Сайн засаглалын гүйцэтгэлийг үнэлэх багт сургалт хийх.
- (г) Орон нутгийн хөгжлийн санд санхүүгийн, техникийн, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

3-р Хэсэг: Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ

Төсөл хэрэгжүүлэхэд дараах техникийн, үйл ажиллагааны болон чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлнэ: (а) Тогтвортой амьжиргаа хөтөлбөрийн

хэрэгжилтийг дэмжих техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж, ажилтнуудыг сургах, мэдээлэл түгээх, хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүгийн удирдлага болон төслийн аудит хийх; (б) Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн зарим хэсэгт сэдэвчилсэн судалгаа хийх; (в) Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх.

ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

1-р Хэсэг: Хэрэгжилтийн зохицуулалтууд

А. Хэрэгжилттэй холбоотой заалтууд

1. Анхны санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.A (Хэрэгжилтийн зохицуулалтууд) болон I.B (Төслийн хэрэгжилт) Хэсэг нь энэхүү А Хэсэгт хамаарагдах бөгөөд энэхүү Хэлэлцээрт давхар хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Хүлээн авагч нь тэдгээр заалтуудыг энэхүү Хэлэлцээрт давхар заасан гэж ойлгон хүлээн зөвшөөрч байгаа болно. Үүнд үл хамаарах зүйлс нь:

(а) Анхны санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.B-ийн эхний хэсэгт буй “2015 оны наймдугаар сарын 1-нээс өмнө” гэсэн заалтыг тооцохгүй;

(б) Анхны санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.B-ийн хоёрдугаар хэсэгт буй 2.(а).(iii) дахь “Хуваарь 2-ийн III хэсэг” гэсэн заалтыг “Худалдан авах ажиллагааны журам” гэж ойлгоно.

2. Энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.A, I.B Хэсгийн хүрээнд холбогдож буй Анхны хэлэлцээрийн заалтуудтай холбоотой асуудлыг илүү тодорхой болгож, эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх үүднээс, энэхүү Хэлэлцээр дуусгавар болохоос өмнө Анхны санхүүжилтийн хэлэлцээр хүчингүй болсон тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудад огт нөлөөлөхгүй бөгөөд 1.A Хэсэг буюу дээрх заалтад тусгасан Анхны санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөлүүд нь Хүлээн авагч болон Ассоциаци хооронд бүрэн хүчин төгөлдөр үйлчилж, Анхны санхүүжилтийн хэлэлцээр хүчингүй болсноос үл хамааран энэхүү хэлэлцээрийн хүрээнд Хүлээн авагч, Банк хооронд хэвээр нөлөөлнө.

Б. Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилт

1. Хүлээн авагч нь Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр хийж буй ажлуудыг Төслийн хэрэгжилтийн гарын авлага болон энэхүү I.B Хэсэгт тусгасан нөхцөлүүдэд заасан зөвлөмж, журам, шаардлагуудад нийцүүлж ажиллана.
2. Хүлээн авагч нь холбогдох болон бусад хууль, эрх зүйн зохицуулалтыг Ассоциацийн шаардлагын дагуу хангаж ажиллана. Ингэхдээ Хүлээн авагч нь Сангийн ямаар дамжуулан Сайн засаглалын гүйцэтгэлд



суурилсан санхүүжилтийг Ассоциацид зөвшөөрөгдсөн нөхцөлийн дагуу холбогдох сумдад олгоно. Ассоциацид зөвшөөрөгдсөн нөхцөлд энэхүү заалтын 2-р хэсгийн заалт хамрагдана.

- (а) Тухайн сум хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Хүлээн авагч нь өөрийн болон Ассоциацийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сумдад олгосон Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг цуцлах, олгосон тохиолдолд буцаан авах эрхээ Сангийн ямаар дамжуулан эдэлнэ.
- (б) Хүлээн авагч нь Сангийн ямаар дамжуулан сум тус бүрийг: (i) Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаагаа Ассоциацийн шаардлагын дагуу хугацаанд нь, үрдүнтэй, эрүүл мэнд, техник, эдийн засаг, санхүү, удирдлага, байгаль орчин, нийгмийн зохих стандарт, туршлагад нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд үүнд Хүлээн авагчаас гадна санхүүжилтийн хөрөнгөөс ашиглаж буй талуудад үйлчлэх Авлигийн эсрэг зөвлөмж болон Эрсдэлээс хамгаалах хэрэгслүүд багтана; (ii) өмнөх 2.(б).(i) дэд хэсэгт заасан үйл ажиллагаанд шаардагдах нөөц хөрөнгийг тухай бүрд нь аль болох түргэн олгох; (iii) энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах; мөн (iv) дэмжигдсэн үйл ажиллагаа, зорилтуудыг биелүүлэх хүрээнд Ассоциацийн шаардлагад нийцсэн үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байдлаар бодлого, журмыг мөрдөх;
- (в) Хүлээн авагч нь Сангийн ямаар дамжуулан сум тус бүрд дараах шаардлагыг тавина. Үүнд: (i) санхүүгийн удирдлагын системийг хэвээр хадгалж, Ассоциацийн шаардлагад нийцэх стандартын дагуу тогтмол санхүүгийн тайлан бэлтгэх. Ингэхдээ хүлээн зөвшөөрсөн ажлуудтай холбоотой үйл ажиллагаа, хөрөнгө, зардал зэргийг тайлагнана; (ii) Ассоциацийн, эсвэл Хүлээн авагчийн хүсэлтийн дагуу Ассоциацийн шаардлагад нийцэх хараат бус аудитын байгууллагаар санхүүгийн тайлангуудад аудит хийлгэх. Ингэхдээ Ассоциацийн шаардлага хангасан нийтээр дагаж мөрддөг аудитын стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийж дууссан даруйд Хүлээн авагч болон Ассоциациад аудит хийлгэсэн тайланг хүлээлгэн өгөх; (iii) зөвшөөрөгдсөн ажлууд, тэдгээрийн үйл ажиллагаа, холбогдох бүртгэл, бичиг баримтуудыг Хүлээн авагч болон Ассоциаци хянах боломжийг хангах; мөн (iv) Хүлээн авагч болон Ассоциацийн явц дунд хүргүүлж болох боломжит хүсэлтийн дагуу бүх мэдээллийг Хүлээн авагч болон Ассоциацид боловсруулж, хүргүүлэх.

В. Эрсдэлээс хамгаалах

1. Хүлээн авагч нь Төслийг зохих эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм, байгаль орчны стандарт, туршлага болон “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд”-ийн хүрээнд хэрэгжүүлнэ.
2. Ассоциаци албан бичгээр зөвшөөрөөгүй тохиолдолд Хүлээн авагч нь “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд”-ийг өөрчилж, нэмэлт оруулж,

- шинэчилж, хүчингүй болгож, хойшлуулахгүй. “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд” болон энэхүү Хэлэлцээрийн заалтууд зөрчилдсөн тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ.
3. Өмнө дурдсан хязгаарлалтуудаас үл хамааран Хүлээн авагч нь Орон нутгийн хөгжлийн сан эсвэл Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үйл ажиллагааны улмаас хэн нэг хүн эсвэл бүлэг хүмүүсийг албадан нүүлгэхгүй, эсвэл орон сууц, газар (нийтийн бэлчээр газар үүнд хамрагдана), эсвэл байгалийн нөөц баялгийн эзэмшил, эзэмших болон ашиглах эрхээ алдагдахгүй байхад анхаарна. Аливаа үйл ажиллагааны улмаас энэ төрлийн албадан нүүлгэн шилжүүлэлт, эсвэл хохирол учирсан тохиолдолд Хүлээн авагч нь: (а) тэдгээр иргэд, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх, эсвэл бусад төрлийн нөхөн олговор олгохын тулд эдгээр үйл ажиллагааг төлөвлөхөөс өмнө Ассоциацид зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, батлуулсан байна; мөн (б) үйл ажиллагааг боловсруулсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.
 4. Хүлээн авагч нь дараах зүйлд анхаарна: (а) Төслийн хүрээний техникийн туслалцаа, загвар, чадавхыг бэхжүүлэх бүх төрлийн зөвлөх үйлчилгээг Ассоциацийн үнэлж, зөвшөөрсөн нөхцөлүүдийн дагуу хэрэгжүүлэх; мөн (б) энэ төрлийн техникийн туслалцаа, загвар, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны нөхцөлийг Ассоциацийн Эрсдэлээс хамгаалах бодлого болон EHS-ийн Зөвлөмжийг мөрдөх шаардлагатай.
 5. Хүлээн авагч нь Төслийн хэрэгжилтийн туршид гомдол хүлээн авах механизмыг Ассоциацийг шаардлага хангасан хэлбэрээр баримтлах, нийтэд ил тод мэдээлснээр Төсөлтэй холбоотой гомдлыг шударгаар, оновчтойгоор хүлээн авч, Ассоциацийн шаардлагад нийцсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна.
 6. Энэхүү хэлэлцээрт хүлээсэн үүргийн хязгаарлалтыг үл харгалзан Хүлээн авагч нь дараах үүргийг хүлээнэ:
 - (а) Төслийн тайлагнах хэсэгт заасны дагуу “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд”-тэй холбогдох тайланг тогтмол цуглуулж, нэгтгэж, Ассоциацид хүлээлгэн өгөхөд шаардагдах бүх арга хэмжээг авч, Ассоциацийн хүсэлтийн дагуу тухай бүрд нь тусдаа тайлан боловсруулна. Энэ төрлийн бүх тайланг Ассоциацийн шаардлагад нийцэх байдлаар боловсруулах бөгөөд тайлан нь дараах болон бусад зүйлсийг агуулна. Үүнд:
 - (i) “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд”-ийн хэрэгжилтийн явц;
 - (ii) “Эрсдэлээс хамгаалах баримт бичгүүд”-ийн хэрэгжилтэд саад болох, эсвэл саад болох эрсдэлтэй нөхцөл байгаа эсэх;
 - мөн (iii) тухайн нөхцөлийг шийдвэрлэхэд болон урьдчилан шийдвэрлэхээр хэрэгжүүлсэн, эсвэл хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нөхцөлүүд;
 - (б) Төсөлтэй холбоотойгоор, эсвэл төсөлд нөлөөлөх байдлаар байгаль орчин, оршин суугчид, олон нийт, эсвэл ажилчдад ихээхэн сөргөөр нөлөөлөх, эсвэл нөлөөлөх боломжтой аливаа осол гарсан тохиолдолд Ассоциацид шуурхай мэдээлнэ.



2-р Хэсэг: Төслийн хяналт-шинжилгээ, тайлагнал ба үнэлгээ

1. Хүлээн авагч нь төслийн хэрэгжилт, явцад гарч буй ахиц, үр дүнгийн талаар Төсөл хэрэгжүүлэх байгууллагаар хагас жил бүрийн эцэст тайлан гаргуулж, тухайн хагас жил дууссанаас хойш хуанлийн нэг сарын дотор Ассоциацид хүргүүлэх арга хэмжээ авна.

3-р Хэсэг: Санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах үйл явц

А. Ерөнхий зүйл

Ерөнхий нөхцөлүүдийн II дугаар зүйл болон Ассоциациас Хүлээн авагчид хүргүүлэх Зарцуулалтын болон санхүүгийн мэдээллийн албан захидлын дагуу Хүлээн авагч нь доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно.

Ангилал	Зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр)	Зардлын санхүүжилтийн хувь хэмжээ (Татвар тооцсон)
(1) Бараа бүтээгдэхүүн, зөвлөхийн бус үйлчилгээ, сургалт, Үйл ажиллагааны нэмэлт зардал	3,200,000	100%
(2) Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	5,600,000	Олгосон санхүүжилтийн 100%
НИЙТ ДҮН	8,800,000	

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд; Хугацаа

1. Дээр дурдсан А хэсгийн заалтаас үл хамаарч энэхүү Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө гарсан аливаа төлбөрт зориулж зарцуулалт хийхгүй. Үүнд нийт дүн нь 1,760,000-тай тэнцэх хэмжээний ЗТЭ-ээс хэтрэхгүй, 2019 оны 11 дүгээр сарын 1-нээс хойш, Гарын үсэг зурахаас өмнө хугацаанд гарсан Зөвшөөрөгдсөн зардлуудад хийгдсэн төлбөр хамаарахгүй.
2. Төсөл дуусгавар болох өдөр 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр байна.

4-р Хэсэг: Бусад зохицуулалтууд

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд материаллаг болон сөрөг нөлөө учруулж болохуйц эрх зүйн орчны өөрчлөлтийг санал болгосон тохиолдолд Хүлээн авагч нь Ассоциацид шуурхай мэдэгдэж, тухайн санал, Төсөл болон энэхүү Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлийн 5.10 дугаар хэсгийн хүрээнд тохиролцсон Санхүүжилт, тус бүрийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийн талаар Хүлээн авагч болон Ассоциаци байр сууриа солилцоно.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Эргэн төлөх зээлийн үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 3 дугаар сарын 1 ба 9 дүгээр сарын 1:	
2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2045 оны 3 дугаар сарын 1 өдрийг дуустал	1.65%
2045 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2050 оны 3 дугаар сарын 1 өдрийг дуустал	3.40%

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсэгт заасны дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ

Нэр томьёо

1. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсгийг хэрэгжүүлэхэд ашиглах, 2006 оны 10 дугаар сарын 15-нд баталж, 2011 оны 1 дүгээр сарын 1-нд болон 2016 оны 7 дугаар сарын 1-нд тус тус шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилт бүхий төслүүдэд ашиглагдах залилан, авилгаас урьдчилан сэргийлэх журам”-ыг хэлнэ.
2. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн III.A хэсэгт буй хүснэгтэд заасан ангиллыг хэлнэ.
3. “БОЭМАБ Зөвлөмж” гэдэг нь Дэлхийн Банк группийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын зөвлөмжийг хэлнэ. Энэхүү зөвлөмж үе үе шинэчлэгддэг тул www.ifc.org/ehsquidelines хуудсанд хэвлэгдсэн байдлаараа үйлчилнэ.
4. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө” эсвэл “БОНХУТ” гэж Хүлээн авагчийн Ассоциациар хүлээн зөвшөөрүүлж, 2012 оны 12 дугаар сард баталж, 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр олон нийтэд мэдээлж, 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр шинэчилж, дахин мэдээлсэн төлөвлөгөөг хэлнэ. Үүнд дараах зүйлсийг тусгасан болно. (а) Төслийн хэрэгжилтийн явцад байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллөөс (үүнд эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлууд багтана) урьдчилан сэргийлэх, бууруулах, эсвэл арилгах, тодорхой түвшинд хүртэл бууруулах арга хэмжээ; [(б) хүйсэд суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл]; (в) эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай процедур, төсөв, институцийн арга хэмжээ, үйл ажиллагаа. Үүнд холбогдох төлөвлөгөөний хуваарийг багтаах бөгөөд Хүлээн авагч энэ төрлийн төлөвлөгөөг тогтмол шинэчлэх шаардлагатай тул тухай бүрд нь урьдчилан Ассоциациас албан бичгээр зөвшөөрөл авах.



5. “Уугуул иргэдийн төлөвлөгөө” гэж Ассоциацийн зөвшөөрөлтэйгөөр Хүлээн авагчийн 2012 оны 12 дугаар сард баталж, 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр олон нийтэд мэдээлж, 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр шинэчилж, дахин мэдээлсэн төлөвлөгөөг хэлнэ. Үүнд Төслийн нөлөөлөлд өртсөн, өртөх магадлалтай, уугуул иргэдтэй бүгдтэй нь зөвшилцөж, мэдээлж, оролцуулах зорилгоор Төслийн хүрээнд хамрагдах уугуул иргэдийн оролцоонд чиглэсэн зөвлөмж, чиглэлийг багтаах бөгөөд Ассоциацийн урьдчилсан зөвшөөрөлтэйгөөр төслийг цаашид өөрчлөх боломжтой тул Төслийн үйл ажиллагаанд уугуул иргэдийн хэрэгцээ, соёлын онцлог, эрхэм зүйлсийг хамруулна.
6. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
7. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 87 дугаар хэсэгт зааснаар 2016 оны 7 дугаар сард баталж, 2017 оны 11 болон 2018 оны 8 дугаар сард тус тус шинэчилсэн “Хөрөнгө оруулалтын төслийн зээлдэгчдэд зориулсан Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
8. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч тал харилцан гарын үсэг зурсан хоёр өдрийн сүүлийнхийг нь хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан “Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо” гэсэн нэр томъёонд мөн хамаарна.
9. “Эрсдэлээс хамгаалах бичиг баримтууд” гэж Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө, Уугуул иргэдийн төлөвлөгөө болон тэдгээртэй холбогдох бүх бичиг баримтуудыг “Эрсдэлээс хамгаалах бичиг баримтууд” гэнэ.
10. “Хамгааллын бодлого” гэж Ассоциацийн Үйл ажиллагааны бодлогууд (ҮАБ) болон Банкны процедурууд (БП), тэр дундаа ҮАБ/БП 4.01 (Байгаль орчны үнэлгээ), ҮАБ/БП 4.04 (Амьтдын амьдрах орчин), ҮАБ/БП 4.09 (Хортон шавж зохицуулалт), ҮАБ/БП 4.10 (Уугуул иргэд), ҮАБ/БП 4.11 (Биет соёлын нөөц), ҮАБ/БП 4.12 (Албадан нүүлгэн шилжүүлэлт), ҮАБ/БП 4.36 (Ой мод), ҮАБ/БП 4.37 (Аюулгүйн далан)-г хэлнэ; эдгээртэй <https://policies.worldbank.org> хаягаар танилцах боломжтой.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 200003